



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар /1336

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар
өмчлүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 163 иргэнд 12.95 га газрыг хавсралт ёсоор өмчлүүлсүгэй.

Хоёр. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/, Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200912